

“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04 сарын 25

№ 22 / 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022. 04. 25-ны өдрийн 14.00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг 2-р хороо Центропонт төв “Бурхан халдун групп” ХХК-ийн хурлын зааланд болов.

Хуралд:

“Дархан зочид буудал” ХК нь 8.945 300 ширхэг хувьцаатайгаас хуралд хувьцаа эзэмшигч:

- 1. Намсрай овогтой Мөнхдаш- 7.109 300 ширхэг хувьцааны саналаар**
- 2. Би Ди Сек ХК – 1.314 590 ширхэг хувьцааны саналаар тус тус оролцов.**

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан **8.945 300 хувьцааны** саналын эрхтэй хувьцааны тоог **8.423 890** ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц **94,1 %** тай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 14 цаг 10 минутад эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга С.Дагиймаа үг хэлэв.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд та бүхэнтэй нээлттэй ярилцаж санал бодлоо хуваалцахын зэрэгцээ өнгөрсөн жилд хийсэн ажлын бүтээмж, үйл ажиллагааны болон санхүүгийн талаар дүгнэж санал бодлоо илэрхийлэх боломж олдож байгаад баяртай байна.Цаашид компанийхаа төлөө тавьсан зорилго зорилтоо хэрэгжүүлж ажиллах үүднээс хамтарч ажиллах, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх алдагдалыг бууруулах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгааг нийт хуралд оролцож буй компаний эрх бүхий албан тушаалтнуудад өөрийн зүгээс байр сууриа илэрхийлэв. Ингээд хурал нээсэнийг мэдэгдэж хурлын дэгийг уншиж танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
- 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах

Тус компанийн 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах талаар төлөвлөөд байна.

СОНССОН НЬ:

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2021 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг танилцуулхад:

- **Үйлчилгээний соёл, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр:**
 1. Сар бүрийн 2.4-р долоо хоногт ажлын байрны үзлэг хяналтыг хийж зөрчил дутагдалыг засаж ажилласан.
 2. Үйлчлүүлж буй зочдын гадаад иргэдийн тоо, харьяалал зэрэг мэдээлэлийг сар бүр судалгаагаар гарган бүртгэл хийж хэвшсэн.
- **Ашиг орлогоо нэмэгдүүлэх менежментийн чиглэлээр:**
 1. Өөрийн нэрийн бууз банш, зууш үйлдвэрлэх цех байгуулан борлуулалт хийж эхэлсэн.
- **Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын чиглэлээр:**
 1. Зочид буудал хангамжийн хэрэгсэл шинэчилсэн.
 2. Өдрийн хоолны хямдралтай үнийн 2 төрлийн багцийн хоолны цэс гарган үйлчилгээ үзүүлсэн.
 3. Дотоод хяналтын чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүрэн засуулж, дотоод хяналт шалгалтын тайланг аймгийн МХГазарт хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2022 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд:

Үйл ажиллагааны чиглэлээр:

- Аймаг орон нутгийнхаа БОАЖГ-аас зохион байгуулагдаж буй үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж оролцох
- Цаашид бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ орлого нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарч ажиллана.
- Зочид буудлын Б корпусын дээвэрийн ажлуудыг хэсэгчлэн хийнэ.

Баг хамт олны олон нийтийн үйл ажиллагаа

- Ажилчдын хөдөлмөр хамгаалалын ажлын дүрэмт хувцсыг олгох
- Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд ажилчдыг бүрэн хамруулах
- Халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлж ажилчдадаа витаминжуулалт хийх

- Үйлчилгээний стандарт харилцаа хандлагын талаарх сэдэвчилсэн төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах

Санхүү мэдээ борлуулалт

- Санхүү нийгмийн даатгалын, татварын тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх
- Бараа материал түүхий эдийн үнийн судалгаа гаргаж хямд чанартай бараа бүтээгдэхүүнээр хангах
- Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллана.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй.
2. “ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн 2021 онд 5 000 000 төгрөгийн ашигтай ажилласан Ковид цар тахлын үед улсын хэмжээнд айл өрх зарим ААН-үүдийн хэрэглээний эрчим хүч, дулаан, усан хангамж, хогны төлбөрийг төрөөс хариуцах шийдвэр гаргасан. Энэхүү тог цахилгаан, дулааны төлбөрийг чөлөөлсөнтэй холбоотойгоор 5 000 000 төгрөгийн ашиг хуримтлагдсан. Энэхүү ашигаас хүнсний бараа материалын хуримтлагдсан өр төлбөрийг суутган төлсөн тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийг баталсугай.
3. 2022 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигтай ажиллах талаар идэвх санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал Л.Ариунзаяа-д даалгасугай. Хурал хэсэг засварласаны дараа тооллогын комисс саналын хуудасыг тоолж тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Хурал 16.40 –д өндөрлөв.

Хурал удирдсан хурлын дарга: /Н.Мөнхдаш/

Протокол бичсэн: /С.Дагиймаа/

